



НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 9165

Улаанбаатар хот

Г Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт т
хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбогдуулан ажлын
тусгай горимд шилжүүлэн ажиллуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.4.2, 10.4.10, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 194 дүгээр тогтоол, Улсын онцгой комиссын 37 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор бүх нийтийн бэлэн байдлын зэргийг хэсэгчилсэн байдлаар шилжүүлэн сунгасантай холбогдуулан гарсан шийдвэрийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллах, дээрх хугацаанд газрын нийт ажилтан албан хаагчдыг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулсугай.

2. Тус газрын үндсэн үйл ажиллагааг цахимаар явуулах боломжгүй нөхцөл байдлыг харгалзан газрын даргын А/62 дугаар тушаалаар баталсан ажилтан, албан хаагчдын ажлын цагийн хуваарийг үргэлжлүүлэн мөрдсүгэй.

3. НЗЗ-ны байруудын инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагаа болон тус байранд мөрдөх дотоод журмыг бүрэн хангаж, байрны ээлжийн ажилтнуудын ажиллах хуваарийг батлуулж, хяналт тавин ажиллахыг Байр ашиглалтын албаны дарга /Г.Батзаяа/, Үйлчилгээний албаны дарга /М.Алтантuya/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжид хяналт тавин удирдлагаар ханган ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга /Ч.Шинэчимэг/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Орлогч дарга /Ч.Однасан, Б.Галмандаа/ нарт тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

C:\Users\Desktop\А тушаал.docx

1150500129

